



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
**АРСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/13

Улаанбаатар хот

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.3 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төвийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх Ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Мядаг)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Баярмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ц.УРАНЧИМЭГ

АӨСҮТ-ийн Захирлын 2024 оны
04 дугаар сарын 04-ний өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт



**АӨСҮТ-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн дагуу
авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө**

№	Аудитын илрүүлэлт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран ажиллах алба, албан тушаалтан
1	2	3	4	5	6
1	Бараа материал худалдан авах гэрээний хэрэгжилт хангалтгүй	Ханган нийлүүлэх байгууллагуудтай хийж байгаа бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай гэрээнүүдийн хамрах хугацаа болон гэрээний хэрэгжилтэнд хяналт хийж сайжруулана.	2024-08-30 хүртэл	САДарга: Б.Мядаг	Аж ахуйн нярав: С.Давааням
2	Эм эмнэлгийн хэрэгслийн гэрээний хэрэгжилт бүрэн бус	Ханган нийлүүлэх байгууллагуудтай хийж байгаа бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай гэрээнүүдийн хамрах хугацаа болон гэрээний хэрэгжилтэнд хяналт хийж сайжруулана	2024-08-30 хүртэл	САДарга: Б.Мядаг ЭЗАДарга: Э.Болорцэцэг	Тооцооны нягтлан бодогч: Б.Ууганчимэг Жор баригч: Р.Энхчимэг
3	Нэмэлт тусламж үйлчилгээний орлогыг бодитой төлөвлөөгүй	Төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн хийж, холбогдох журмыг боловсруулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллах	2024-08-30 хүртэл	САДарга: Б.Мядаг Эдийн засагч: Ц.Амарзаяа	Дотоод аудитор
4	Дотоод хяналтын зөвлөх үйлчилгээ үр дүнгүй	Дотоод аудиторын сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, үр дүнтэй зохион байгуулж, аудиторыг сонгохдоо мэдлэг, ур чадварыг нь харгалзан үзэх, олон улсын стандарт болон дотоодын туршлага дахь мэргэшсэн байдалд дүн шинжилгээ хийх, хийх ажил, гарах үр дүнг гэрээнд тодорхой тусгах, гэрээний хяналтыг сайжруулж, үр дүнтэй ажиллана	2024-08-30 хүртэл	ҮАЭДЗахирал: Т.Баярмаа ХНАДарга:	САДарга: Б.Мядаг